



СОЁЛ-ХҮНИЙ ХӨГЖИЛ

Тогтвортой ноолуурын ёсзүйг тайлах нь

Ноолуур, ноолууран бүтээгдэхүүн
үйлдвэрлэлийн салбарын шинжилгээ -
Статистикийн эмхтгэл

Соёл-Хүний Хөгжил Судалгааны Төв

Энэхүү тайланг Канад Улсын Нийгэм, Хүмүүнлэгийн Шинжлэх Ухааны Хорооны санхүүжилтээр ЮНЕСКО-ийн ивээл дор Нүүдлийн Соёл Иргэншлийг Судлах Олон Улсын Хүрээлэн, Канадын Виннипегийн их сургуультай хамтран хэрэгжүүлж буй “ТОГТВОРТОЙ НООЛУУР: ЁС ЗҮЙГ ТАЙЛАХ НЬ” сэдэвт судалгааны ажлын хүрээнд хийж гүйцэтгэв.

Зохиосон:

Л.Ундрал (Үндэсний статистикийн хороо)

Удирдсан:

Х.Наранцацрал (Хуульзүйн үндэсний хүрээлэн)

Эрик Трифт (Виннипегийн Их Сургууль)

Улаанбаатар хот

2022 он

Агуулга

Агуулга	3
Товчлол	4
Хураангуй	5
Ноолуур үйлдвэрлэлийн салбарт төрөөс авч хэрэгжүүлж буй бодлого, хөрөнгө оруулалт	7
Монгол улсын ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэл	10
Ноолууран бүтээгдэхүүний түүхий эдийн ханган нийлүүлэлт, ажиллах хүч	10
Ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлт	17
Ноолуур, ноолууран бүтээгдэхүүний монгол улсын эдийн засагт үзүүлэх үр нөлөө	23
Ноолуурын үнэ, ханш	24
Ноолуур, ноолууран бүтээгдэхүүний экспорт	26
Дэлхийн зах зээлийн ноолуурын ханган нийлүүлэгчид	34
Дүгнэлт	38
Ашигласан материал	42
Цахим мэдээллүүд	42

Товчлол

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ДНБ	Дотоодын Нийт Бүтээгдэхүүн
ЗГ	Засгийн Газар
МХАҮТ	Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
ОХУ	Оросын Холбооны Улс
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ХБНГАУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХК	Хувьцаат компани
ХХААХҮЯ	Хүнс, Хөдөө аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яам

Хураангуй

Ноолуурын зах зээл нь Монгол улсын эдийн засагт чухал байр суурь эзэлдэг. Малчдын хувьд ноолуур нь амьжиргааны гол эх үүсвэр болж байдаг бол уул уурхайн бус салбарын тэргүүлэгч экспортын бүтээгдэхүүн гэдэг утгаараа эдийн засагт үзүүлэх ач холбогдол нь мөн их байдаг.

Монгол улсын засгийн газраас ноолуур үйлдвэрлэлийн салбарыг тусгайлан авч үзсэн бодлогын хөтөлбөр бол “Ноолуур” хөтөлбөр юм. Ноолуурын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн техник, технологийг хөгжүүлэх, эцсийн бүтээгдэхүүний нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, экспортыг дэмжих зорилгоор “Ноолуур” хөтөлбөрийг анх 2000-2006 онуудад хэрэгжүүлсэн ба 2018-2021 онуудад дахин баталж, хэрэгжүүлсэн. Мөн ноолуурын салбарыг дэмжих зорилгоор 2011-2020 оны хооронд 183 аж ахуйн нэгж байгууллагад 726.8 тэрбум төгрөгийн хөнгөлттэй зээлийг олгосон байна.

Монгол улсын нийт малын тоо 1970 онтой харьцуулахад 3 дахин өсөж 67.3 сая толгойд хүрсэн бол ямааны тоо 6.3 дахин өсөж 26.5 саяад хүрсэн байна. 2021 оны байдлаар 920.2 мянган өрх байгаагийн 188.6 мянган нь жилийн дөрвөн улиралд малаа малладаг, малын ашиг шим нь амьжиргааны эх үүсвэр нь болдог өрхүүд байна. Нэг малчин өрхөд ногдох ямааны тоо дунджаар 67-оос 146 толгой болж 2.2 дахин нэмэгдсэн байна.

2021 оны дүнгээр нийт 10.1 мянган тонн ноолуур бэлтгэсэн ба энэ нь өмнөх оноосоо 6 хувиар буурсан хэдий ч 2001 оноос 3.3 дахин нэмэгдсэн дүн юм. Ноолуурын үйлдвэрлэлийг харвал ямааны тооны өсөлтэй ижил хандлагатай өөрчлөгдсөн ба сүүлийн жилүүдэд малчид малын чанарт бус тоонд анхаарч малаа өсгөснөөс, түүхий эдийн чанар болон нэг малаас авах ашиг шимийн хэмжээ буурсан гэж дүгнэгдэх болсон байна. Нийт ноолуурын ойролцоогоор 50-иас дээш хувийг Өмнөговь, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Дундговь, Ховд, Хөвсгөл аймгууд бүрдүүлдэг байна.

2011 оны байдлаар нийт бэлтгэсэн 6.5 мянган тонн ноолуурын 3.0 хувийг дотоодын үйлдвэрт угааж байсан бол цар тахлын өмнөх үе болох 2019 онд 12.9 хувийг, 2021 онд 22.1 хувийг угаасан. Самнасан ноолуурын хувьд нийт бэлтгэсэн ноолуурын 2011 онд 16.0 хувь, 2019 онд 7.8 хувь, 2021 онд 5.1 хувь, ноолууран ээрмэлийн хувьд 2011 онд 3.9 хувь, 2019 онд 3.4 хувь, 2021 онд 0.5 хувиар ноолууран ээрмэл бэлтгэсэн байна.

2021 онд угаасан ноолуур мэдэгдэхүйц хэмжээгээр нэмэгдсэн. Энэ нь Хятад улс Ковид-19-ийн тархалттай нөлөөгөөр хилээ хаасантай холбоотойгоор дотоодын үйлдвэрт угааж, бэлтгэх нь ихэссэн байж болно. Гэхдээ, үүнийг дагаад самнасан болон ноолууран ээрмэл бэлтгэх үйл явц тэр хэмжээгээр нэмэгдээгүй. Эсрэгээрээ 2021 онд ноолууран ээрмэлийн үйлдвэрлэл 245.5 тонноос 47.4 тонн болж, 80 гаруй хувиар буурчээ. Үүнийг мөн цар тахлын нөлөөгөөр экспортын үйл ажиллагаа саарсан, өрхийн орлого буурч, хэрэглэгчийн зан төлөв өөрчлөгдсөн, жуулчдын тоо багассан зэргээс шалтгаалан эрэлт багассантай холбон тайлбарлах боломжтой юм.

2012 оныг хүртэл жилд дунджаар нийт ноолуурын үйлдвэрлэлийн 21 орчим хувийг дотоодын үйлдвэрт самнадаг байсан бол 2021 оны дүнгээр 5 хувь болж буурсан. 2012 оноос хойш 2017-2018 онуудад хамгийн их боловсруулалт хийгдэж байсан бол 2020 оноос 512 тонн болж, 2018 оноос 55.5 хувиар, 2019 оноос 33.2 хувиар буурсан.

Сүүлийн 20 жилийн хугацаанд 2002-2006 онуудад хамгийн их буюу жилд 3.4-5.6 сая ширхэг сүлжмэл, нэхмэл, эдлэлийг үйлдвэрлэсэн. Үйлдвэрлэлийн хэмжээ 2007 оноос эрс буурч, жилд дунджаар ойролцоогоор 760 мянган ширхэг бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн бол 2017 оноос сэргэж, 2019 онд 1,730 мянгад хүрсэн ч 2020 оноос буурч, 2021 онд 2019 оноос 3.3 дахин буурч 524 мянгад хүрчээ.

2019 оны байдлаар сүлжих үйлдвэрлэл хувьд хүчин чадлын ашиглалтаараа хамгийн их буюу нийт суурилагдсан хүчин чадлын 66.1 хувийг үйлдвэрлэлд ашигладаг бол угаах, хялгас ялгах, ээрэх, нэхэх үйлдвэрлэлийн хувьд суурилагдсан хүчин чадлынхаа 24.9-31.5 хувийг л ашиглаж байдаг байна.

Нэг килограмм ноолуурын үнэ сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байсан ч 2020 онд мэдэгдэхүйц хэмжээгээр буурсан. Энэ нь мөн цар тахалтай холбоотойгоор улс орнууд хилээ хаасан, тээвэр ложистикийн асуудлу

Ноолуур үйлдвэрлэлийн салбарт төрөөс авч хэрэгжүүлж буй бодлого, хөрөнгө оруулалт

Ноолуурын зах зээл нь Монгол улсын эдийн засагт чухал байр суурь эзэлдэг. Малчдын хувьд ноолуур нь амьжиргааны гол эх үүсвэр болж байдаг бол уул уурхайн бус салбарын тэргүүлэгч экспортын бүтээгдэхүүн гэдэг утгаараа эдийн засагт үзүүлэх ач холбогдол ч мөн их юм. Монгол улсын хувьд дэлхийн зах зээлийн ноолуурын хоёрдогч гол нийлүүлэгч орон ба нийт зах зээлийн 40 орчим хувийг бүрдүүлж байна.

Урт хугацааны хөтөлбөр	Дунд хугацааны хөтөлбөр	Богино хугацааны хөтөлбөр
Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030	Төрөөс малчдын талаар баримтлах бодлого	Монгол улсын засгийн газрын дөрвөн жилийн үйл ажиллагааны хөтөлбөр
Алсын хараа-2050	Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого	Үйлдвэржилт 21:100 хөтөлбөр, Монгол экспорт хөтөлбөр
Ногоон хөгжлийн бодлого	Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого	Ноолуур хөтөлбөр
Гурван тулгуурт хөгжлийн бодлого		

Хүснэгт 1. Төрөөс боловсруулах үйлдвэрлэлийн салбарт баримталж буй бодлогууд

Монгол улсын засгийн газраас боловсруулах үйлдвэрийн салбарыг дэмжих, эдийн засгийг сэргээх зорилгоор үндэсний хэмжээний урт хугацааны Алсын хараа-2050, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Ногоон хөгжлийн бодлого, Гурван тулгуурт хөгжлийн бодлого, дунд хугацааны Төрөөс малчдын талаар баримтлах

бодлого, Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, богино хугацаанд Монгол улсын засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Үйлдвэржилт: 21:100, Ноолуур хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдийг боловсруулж, хэрэгжүүлж байна.

Ноолуур үйлдвэрлэлийн салбарыг тусгайлан авч үзсэн бодлогын хөтөлбөр бол “Ноолуур” хөтөлбөр юм. Ноолуурын түүхий эдийн ихэнх хэсэг нь маш бага татвартайгаар гадагш өртөг шингээлгүй, угаасан байдлаар экспортод гардаг, үүнээс шалтгаалан дотоодын үйлдвэрүүд түүхий эдийн хомсдолд орж, суурилагдсан хүчин чадлаа хангалттай түвшинд ашигладаггүй, үүнийгээ дагаад ажилчдын цалин хөлсийг нэмэгдүүлж чаддаггүй, мөн ажиллах хүчний хомсдолд өртөх зэрэг сөрөг үр дагаврууд бий болдог. Эдгээр сөрөг үр нөлөөг бууруулах зорилгоор ноолуурын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн техник, технологийг хөгжүүлэх, эцсийн бүтээгдэхүүний нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, экспортыг дэмжих зорилгоор “Ноолуур” хөтөлбөрийг анх 2000 онд Засгийн газрын 114-р тогтоолоор баталж 3-н үе шаттайгаар 2000-2006 онуудад хэрэгжүүлсэн ба 2018 оны 47-р тогтоолоор 2 үе шаттайгаар 2018-2021 онуудад дахин баталж, хэрэгжүүлсэн. Мөн засгийн газраас уул уурхайн олборлох, баяжуулах үйлдвэрлэлээс бусад аж үйлдвэрийн салбарыг хамруулсан “Үйлдвэржилт 21:100” хөтөлбөрийг 2 үе шаттайгаар 2018-2021 онуудад хэрэгжүүлсэн. Уг хөтөлбөрийн хэрэгжүүлэх ажлын хүрээнд ноос, ноолуур, арьс ширэн түүхий эдийн бэлтгэл, тээвэрлэлтийн тогтолцоог боловсронгуй болгох, үндэсний үйлдвэрт тогтвортой нийлүүлэх, түүхий эдийн санг бий болгох, үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүний худалдааг дэмжих эрхзүйн орчныг боловсронгуй болгох, түүнчлэн, ноос, ноолууран түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшинг 2016 оны суурь түвшин 20-н хувиас 60 хувьд хүргэх зэргээр тусгаарлуулж өгсөн.

Засгийн газраас ноолуурын салбарыг дэмжих бодлогын баримт бичгүүдийг боловсруулж хэрэгжүүлсэнтэй зэрэгцээд ноолуурын салбарт оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсэн. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ)-ны 2021 оны мэдээллээр 2011-2020 оны хооронд ноолуурын салбарыг дэмжих зорилгоор 183 аж ахуйн нэгж байгууллагад 726.8 тэрбум төгрөгийн хөнгөлттэй зээлийг олгосон байна.

Хүснэгт 2. Ноолуурын салбарын хөрөнгө оруулалт


Он	Эрх зүйн үндэслэл	Зориулалт	Аж ахуйн нэгж байгууллагын тоо	Зээлийн хэмжээ, тэрбум төгрөгөөр
2011	ЗГ-ын 221, 368 дугаар тогтоол	Үндэсний үйлдвэрлэгчийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх	37	98.6
2013	ЗГ-ын 126, 165 дугаар тогтоол	Техник, технологийн шинэчлэл	44	95.3
2014	ЗГ-ын 126 дугаар тогтоол	Эргэлтийн хөрөнгийн зээл	7	29.3
2015	ЗГ-ын 149 дугаар тогтоол	Эргэлтийн хөрөнгийн зээл	8	56.1
2017	Ноолуурын эргэлтийн хөрөнгийг дэмжих	Эргэлтийн хөрөнгийн зээл	9	67.1
2018	Ноолуур хөтөлбөр	Эргэлтийн хөрөнгийн зээл	20	194.4
2019	Ноолуур хөтөлбөр	Эргэлтийн хөрөнгийн зээл	14	82.1
2020	Ноолуур хөтөлбөр, ЗГ- ын 101 дүгээр тогтоол	Эргэлтийн хөрөнгийн зээл	44	103.9

Эх үүсвэр: ХХААХҮЯ, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, 2021

Монгол улсын ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Ноолууран бүтээгдэхүүний түүхий эдийн ханган нийлүүлэлт, ажиллах хүч


Ноолуур, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарын чухал оролцогч нар бол малчид болон үйлдвэрлэгчид юм. Өнөөгийн байдлаар Монгол улсын нийт малын тоо 1970 онтой харьцуулахад 3 дахин өсөж 67.3 сая толгойд хүрсэн бол ямааны тоо 6.3 дахин өсөж 4.2-аас 26.5 сая хүрсэн байна. Энэ нь нийт таван хошуу малын 20 орчим нь ямаа байсан бол энэ нь хоёр дахин ойролцоогоор 40 хувьд хүрсэнг харуулж байна.



Зураг 1. Малын тоо, сая толгойгоор. Эх үүсвэр: YCX, www.1212.mn

Малын тооны мэдэгдэхүйц бууралт 2002, 2010 онуудад ажиглагдсан нь байгалийн гамшигт үзэгдэлтэй холбон тайлбарлаж болох юм. Судлаач С.Сайнбаяр ба бус., (2021)-ийн 1990-2020 оны хооронд болсон байгалийн гамшигт үзэгдэл болох зудын мэдээлэлд үндэслэсэн судалгааны дүнгээр хамгийн томоохон хохирол ихтэй зуд нийт 15 аймгийг хамарч, 4.6 сая мал хорогдсон 2001 оны зуд, 7 аймгийг хамарч, 5.3 сая толгой мал хорогдсон 2009 оны зуд байсан байна. Мөн энэ судалдгаанд зуд нь хүн амын шилжилт хөдөлгөөнийг идэвхжүүлж, улмаар хөдөө аж ахуйн салбарт сөрөг нөлөөллийг ихэсгэх магадлалтайг тогтоосон.

2021 оны байдлаар 920.2 мянган өрх байгаагийн 246.3 мянга (26.8%) нь малтай өрх байгаа бол үүнээс 76.6 хувь буюу 188.6 мянган нь жилийн дөрвөн улиралд малаа малладаг, малын ашиг шим нь амьжиргааны эх үүсвэр нь болдог өрхүүд байна. Тэгвэл нийт өрхөд малчин өрхийн эзлэх хувийг авч үзвэл 1990-2000 онуудад жил бүр өсөж байсан ба дунджаар нийт өрхийн 30.4 хувь байсан. 1990 оноос хойш малчин өрхийн тоо мэдэгдэхүйц нэмэгдсэн нь нэгдлийн малыг иргэдэд хувьчилж эхэлсэнтэй холбон тайлбарлаж болох юм. Харин 2001 оноос 2015 оныг хүртэл тасралтгүй буурсаар 17.8 хувьд хүрчээ. Энэ нь С.Сайнбаяр ба бус., (2021)-ийн судалгаанаас үзэхэд хохирол ихээхэнд тооцогдох зуд 1999-2003, 2009-2010 онуудад болсон, зуд нь хүн амын шилжилт хөдөлгөөнийг идэвхжүүлэх магадлалтай гэсэн дүгнэлттэй нийцэж байна. 2015 оноос малчдын шилжилт хөдөлгөөн тогтворжиж, мал аж ахуй эрхэлдэг өрхийн тоо аажмаар нэмэгдэж 2021 онд 20.5 хувь болж өссөн.



Зураг 2. Малчин өрхийн тоо, мянган өрхөөр, нийт өрхөд эзлэх хувь. Эх үүсвэр: ҮСХ, www.1212.mn


Нэг өрхөд ногдох малын тоо 1990-2010 онуудад дунджаар 190 толгой байсан бол 2011-2021 онуудад 350 болж, 1.8 дахин их нэмэгджээ. Ямааны тооны хувьд дунджаар 67-оос 146 толгой болж 2.2 дахин нэмэгдсэн байна.



Зураг 3. Нэг малчин өрхөд ногдох малын тоо. Эх үүсвэр: ҮСХ, www.1212.mn


Мал аж ахуй эрхэлдэг өрхийн тоо тасралтгүй 2000 оныг хүртэл өсөж, нийт өрхийн 35 хувьд хүрсэнг өмнө дурдсан ба 2021 оны байдлаар уг үзүүлэлт 20 хувьд хүрч буурсан.

Үүнийг аймгаар задалж авч үзвэл Сэлэнгэ аймгаас бусад бүх аймгуудад мал малладаг өрхийн тоо буурсан. Хамгийн их өөрчлөлттэй байгаа аймаг нь Өмнөговь, Ховд, Баянхонгор аймгууд байна. Өмнөговь аймаг нь 2000 онд нийт өрхийн 61 хувь нь малчин байсан бол 2021 оны байдлаар 29 хувь болж 32 пунктээр буурсан, үүний дараа Ховд аймгийн хувьд 58 хувиас 37 хувь болж 21 пунктээр, Баянхонгор аймгийн хувьд 68 хувиас 49 хувь болж 19 пунктээр буурчээ. Уг өөрчлөлтүүд нь байгалийн гамшигт үзэгдэл болсноос гадна эдгээр аймгуудад 2000 оны эхэн үеэс уул уурхайн үйл ажиллагаа идэвхжиж, иргэд уул уурхайн компани болон гар аргаар бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг болсонтой холбон тайлбарлагдаж болох юм. 2021 оны байдлаар Архангай, Өвөрхангай, Дундговь, Говь-Алтай аймгууд нийт өрхийн 50-иас дээш хувь нь малчин өрхүүд байна.




Зураг 4. Нийт өрхөд малчин өрхийн эзлэх хувь, аймгаар, 2000, 2021. Эх үүсвэр: ҮСХ, www.1212.mn

Малын тоо толгой сүүлийн жилүүдэд нэмэгдсэн ч таван хошуу малын харьцаа, сүргийн бүтцэд томоохон өөрчлөлтүүд гарсан. Бог мал дахь хонь ямааны харьцаа 1990 он хүртэл 75:25 буюу 3 хонинд 1 ямаа ногдож байсан бол ямааны тоо толгой ноолуур үнийн өсөлттэй холбоотойгоор 1993 оноос эрс өсөж эхэлж, 2003 онд 50:50 харьцаанд ирсэн бол 2009 он хүртэл хонины тооноос давж гарсан байдаг. 2021 оны байдлаар энэ харьцаа 54:46 харьцаатай байна.




Зураг 5. Бог малд хонь, ямааны эзлэх хувь. Эх үүсвэр: ҮСХ, www.1212.mn

Тэгвэл нийт ямааны тоогоор Хөвсгөл аймгийн хувьд 2.2 сая толгойг тоолуулж тэргүүлсэн бол Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сум 264.4 мянга, Өмнөговь аймгийн Номгон сум 218.6 мянга, Ховд аймгийн Булган сум 192.9 мянга, Дундговь аймгийн Эрдэнэдалай сум 191.1 мянга, Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сум 188.1 мянган ямаа тоолуулж хамгийн олон ямаа тоолуулсан 5-н сум болсон байна.



Зураг 6. Ямааны тоо, аймаг, сумаар, 2021. Эх үүсвэр: ҮСХ, 2022

ХХААХҮЯ-наас 2020 онд 9.4 мянган тонн ноолуур бэлтгэхээр тооцоолсон. Тэгвэл уг тооцооллоос харахад нийт ноолуурын 50-иас дээш хувийг Өмнөговь (9.1%), Өвөрхангай (8.8%), Баянхонгор (8.2%), Говь-Алтай (7.3%), Дундговь (7.2%), Ховд (7.0%), Хөвсгөл (6.9%) аймгууд бүрдүүлэхээр төлөвлөжээ.




Зураг 7. Ноолуур бэлтгэх төлөвлөгөө, тонноор, аймгаар 2020. Эх үүсвэр: ХХААХҮЯ, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийн газар, 2021

Нэг. Ямааны ноолуурын гари, чанар, ялгаа. Монгол үйлдвэрийн ямааг байгаль цаг уурын эрс тэс нөхцөлд бэлчээрээр маллахад бүрэн зохилдсон, ялангуяа говь, цөлөрхөг болон өндөр уулын бэлчээрийг ашиглах чадвартай биологийн өвөрмөц онцлогтой, ноолуурын ширхэгт байгалийн үндсэн дөрвөн суурь өнгийг шингээсэн гэж үздэг. Цайвар ноолуураар олон төрлийн өнгө гаргаж авах бол бараан ноолуураар бараан бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх л боломжтой байдаг. Монгол ноолуурын хувьд нийт ноолуурын ойролцоогоор 60 хувь нь бараан, 15 хувь нь улаан, 10 хувь нь саарал, 10 хувь нь цайвар саарал ноолуур байна (ХХААХҮЯ). Ямааны ноолуурын шинж чанарын гол үзүүлэлт нь ноолуурын дундаж голч микрон ба энэ нь 15.0-16.5, урт нь 40-45 мм байх ба ямааны нас хүйс, үүлдэрлэг байдлаас хамаарч ялгаатай байна. Ямааны ноолуурыг өнгө болон чанараар нь дараах байдлаар ангилдаг.

Ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлт

Ноолуурын ширхэг нь байгалиас нано бүтэцтэй учир дээд зэргийн зөөлөн, хөнгөн, дулаан, уян хатан, бат бөх, амьсгалдаг, агаар шүүдэг, галд тэсвэртэй, байгальд задардаг зэрэг хүний эрүүл мэнд, байгальд ээлтэй үзүүлэлтээрээ зах зээлд ноолууран бүтээгдэхүүн нь тансаг хэрэглээний бүтээгдэхүүнд тооцогддог, ялангуяа өндөр хөгжилтэй орнуудад эрэлт өндөртэй байдаг. Түүхий ноолуур шороо, хаг, ургамлын хог болон бусад биетийг агуулсан байдаг ба бохирдлыг угааж, машинаар самнах байдлаар цэвэрлэх шаардлагатай болдог. Ноолууран эцсийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхийн тулд түүхий элийг ангилах, угаах, хялгас ялгах зорилгоор самнах, үүний дараа ээрэх, сүлжих, нэхэх замаар бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх гэсэн дөрвөн шатыг дамждаг. Түүхий ноолуураас бохирдлыг арилган, нэхмэл, сүлжмэл хувцас, хэрэглэлийг үйлдвэрлэхэд шаардлага хангасан хэмжээ дунджаар 45 хувь байдаг (ХХААХҮЯ).



Зураг 9. Ноолууран бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл явц. Эх үүсвэр: ХХААХҮЯ

Ноолуур боловсруулах салбарт гүн боловсруулах үйлдвэр 15, анхан шатны боловсруулах үйлдвэр 23, сүлжмэлийн жижиг дунд үйлдвэр 59, өрхийн жижиг цех 150-200 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна (ХХААХҮЯ). Байнгын ажлын байрны тоо 2017 оны дүнгээр 5582 байна.



Зураг 10. Ноолуурын нийт үйлдвэрлэл, ямааны тоо. Эх үүсвэр: ҮСХ, www.1212.mn

Зураг 10-аас харахад сүүлийн 20 жилийн ноолуурын үйлдвэрлэл (түүхий ноолуурын хэмжээ)-ийг харвал ямааны тооны өсөлтэй ижил хандлагатай байна. 2000 оны эхний жилүүдэд ноолуурын үйлдвэрлэлийн хэмжээ бууралттай байсан бол 2004-2010 жилд дунджаар 15.2 хувийн өсөлттэй байсан. 2010 онд малын хорогдол их байсантай холбоотойгоор ямааны тоо 5.8 саяар буурсан нь ноолуурын үйлдвэрлэлд нөлөөлж ойролцоогоор 1 мянган тонноор буурч, эргээд өссөн байна. 2021 оны дүнгээр нийт 10.1 мянган тонн ноолуур бэлтгэсэн ба энэ нь өмнөх оныхоосоо 6 хувиар буурсан хэдий ч 2001 оноос 3.3 дахин нэмэгдсэн дүнтэй юм. Сүүлийн жилүүдэд малын эрүүл мэнд, удмын сангийн бодлого алдагдаж, малчид малын чанарт бус тоонд анхаарч малаа өсгөснөөс, түүхий эдийн чанар болон нэг малаас авах ашиг шимийн хэмжээ буурсан гэж дүгнэх болсон байна.

Нийт үйлдвэрлэлийн хэмжээ сүүлийн жилүүдэд нэмэгдсээр ирсэн ба жилд дунджаар 8.5 мянган тонн ноолуур бэлтгэж байна. Эдгээр бэлтгэсэн ноолуурын дотоодын үйлдвэрт хэдий хэмжээг нь угаах, самнах болон ноолуурын ээрмэл бэлтгэж байгааг Хүснэгт 4-д харуулав. 2011 оны байдлаар нийт бэлтгэсэн 6.5 мянган тонн ноолуурын 3.0 хувийг дотоодын үйлдвэрт угааж байсан бол цар тахлын өмнөх үе болох 2019 онд 12.9 хувийг, 2021 онд 22.1 хувийг угаасан. Самнасан ноолуурын хувьд нийт бэлтгэсэн ноолуурын 2011 онд 16.0 хувь, 2019 онд 7.8 хувь, 2021 онд 5.1

хувь, ноолууран ээрмэлийн хувьд 2011 онд 3.9 хувь, 2019 онд 3.4 хувь, 2021 онд 0.5 хувиар ноолууран ээрмэл бэлтгэсэн байна.

Хүснэгт 4. Дотоодын ноолуурын үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн, тонноор

	Нийт бэлтгэсэн ноолуур	Угаасан ноолуур	Самнасан ноолуур	Ноолууран ээрмэл
2010	6,515.80	-	824.70	-
2011	5,471.70	161.60	874.30	212.00
2012	6,325.90	577.10	417.00	225.00
2013	7,009.90	771.70	521.80	270.70
2014	7,726.90	651.00	633.20	314.90
2015	8,857.50	2,204.10	754.50	306.40
2016	9,449.60	2,172.50	776.30	357.80
2017	9,330.15	1,114.00	1,101.80	425.70
2018	9,966.62	1,331.80	1,160.30	492.10
2019	9,972.14	1,288.50	774.00	334.20
2020	10,764.14	845.00	516.70	245.50
2021	10,092.25	2,235.20	511.73	47.40

Эх үүсвэр: YCX, www.1212.mn

Ноолуурыг хамгийн их хэмжээгээр буюу нийт бэлтгэсэн ноолуурын 20-иос дээш хувийг 2015-2019 болон 2021 онуудад дотооддоо угааж байсан бол 2017, 2018 онуудад хамгийн их хэмжээгээр самнах болон ноолууран ээрмэл бэлтгэсэн. 2021 онд угаасан ноолуур мэдэгдэхүйц хэмжээгээр нэмэгдсэн байгаа нь Хятад улс Ковид-19-ийн тархалттай холбоотойгоор хилээ хаасан нь түүхий ноолуурыг шууд экспортод гаргах нь багасаж, дотоодын үйлдвэрт угааж, бэлтгэх нь ихэссэн байх боломжтой юм. Гэхдээ, үүнийг дагаад самнасан болон ноолууран ээрмэл бэлтгэх үйл явц тэр хэмжээгээр нэмэгдээгүй нь харагдаж байна. Эсрэгээрээ ноолууран ээрмэлийн


үйлдвэрлэл 245.5 тонноос 47.4 тонн болж, 80 гаруй хувиар буурчээ. Үүнийг мөн экспортын үйл ажиллагаа саарсан, өрхийн орлого буурч, хэрэглэгчийн зан төлөвт өөрчлөгдсөн, жуулчдын тоо багассан зэргээс шалтгаалан эрэлт багассантай холбон тайлбарлаж болох юм. Тухайлбал, энэ нь ноолуур салбарын хамгийн том аж ахуйн нэгж болох Говь ХК-ны 2020 оны тайланд дотоодын зах зээлийн борлуулалтын орлого нь 2019 онтой харьцуулахад 63 хувиар, гадаад зах зээлийн борлуулалт 45 хувиар буурсан гэж танилцуулсантай нийцэж байгаа юм.

Дотоодын үйлдвэрт самнасан ноолуурын хэмжээг дэлгэрэнгүйгээр авч үзвэл самнасан ноолуур хэмжээ 2006 онд өмнөх оноосоо 1.3 дахин нэмэгдэж байсан ба сүүлийн 20 жилийн хугацаанд 2006-2009 оны хооронд хамгийн их хэмжээгээр (1388-1724 тонн) дотоодын үйлдвэрт самнасан байдаг. 2012 оныг хүртэл жилд дунджаар нийт үйлдвэрлэлийн 21 орчим хувийг дотоодын үйлдвэрт самнадаг байсан бол 2021 оны дүнгээр 5 хувь болж буурчээ. Өөрөөр хэлбэл, ноолуурын үйлдвэрлэлийн хэмжээ эрс нэмэгдсэн ч дотоодын үйлдвэрлэлд тэр хэмжээний мэдэгдэхүйц өөрчлөлт гараагүй байгаа нь харагдаж байна. Дотоодын үйлдвэрт самнасан ноолуурын хэмжээ 2012 оноос хойш 2017-2018 онуудад хамгийн их боловсруулалт хийгдэж байсан бол 2020 оноос 517 тонн болж, 2018 оноос 55.5 хувиар, өмнөх оноосоо 33.2 хувиар буурсан.




Зураг 11. Нийт самнасан ноолуурын хэмжээ, тонноор, нийт бэлтгэсэн ноолуурт эзлэх хувь, самнасан ноолуурын өсөлтийн хувь. Эх үүсвэр: YCX, www.1212.mn

Дотоодын үйлдвэрт үйлдвэрлэсэн нийт нэхмэл, сүлжмэл үйлдвэрлэлийн тоо хэмжээнээс харахад сүүлийн 20 жилийн хугацаанд 2002-2006 онуудад хамгийн их буюу жилд 3.4-5.6 сая ширхэг бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн. 2007 оноос үйлдвэрлэлийн хэмжээ эрс буурч, жилд дунджаар ойролцоогоор 760 мянган ширхэг бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн бол 2017 оноос сэргэж 2019 онд 1730 мянгад хүрсэн ч 2020 оноос буурч, 2021 онд 2019 оноос 3.3 дахин буурч 524 мянгад хүрчээ. Эдгээр самнасан ноолуур болон үйлдвэрлэсэн нэхмэл, сүлжмэл эдлэлийн бууралтыг нь Ковид-19 цар тахлын тархалттай холбоотойгоор үйлдвэрийн хэвийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлсэн байх боломжтой юм.



Зураг 12. Дотоодын үйлдвэрт боловсруулсан нэхмэл, сүлжмэл эдлэлийн тоо. Эх үүсвэр: УСХ, www.1212.mn

Зураг 13-д ноолуурын үйлдвэрлэлийн үйл явц бүрийн хувьд 2019 оны байдлаар суурилагдсан хүчин чадал болон ашиглалтын талаарх мэдээллийг харуулсан. Сүлжих үйлдвэрлэлийн хувьд хүчин чадлын ашиглалтаараа хамгийн их буюу нийт суурилагдсан хүчин чадлын 66.1 хувийг үйлдвэрлэлд ашиглаж байна. Харин угаах, хялгас ялгах, ээрэх, нэхэх үйлдвэрлэлийн хувьд суурилагдсан хүчин чадлынхаа 24.9-31.5 хувийг л ашиглаж байна. Энэ нь нэг талаараа түүхий эдийн бэлтгэлийн улирал буюу жил бүрийн 3, 4 дүгээр сард гадаадын худалдаа эрхлэгчид сайн чанарын түүхий эдийг бэлэн мөнгөөр худалдан авч, маш бага татвар төлж, экспортын татваргүйгээр түүхий эдийн ихэнх хувийг ямар ч өртөг шингээлгүй, угаасан байдлаар экспортод гаргаснаар дотоодын үйлдвэрүүд түүхий эдийн хомсдолд орж, үйлдвэрлэлийн хүчин чадлыг бүрэн ашиглаж чадахгүй нөхцөлд хүргэж байж болох юм.




Зураг 13. Ноолуурын үйлдвэрлэлийн суурилагдсан хүчин чадал, ашиглалтын хэмжээ, 2019. Эх үүсвэр: ХХААХҮЧ, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийн зохицуулах газар, 2021

Ноолуур, ноолууран бүтээгдэхүүний монгол улсын эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Монгол улсын эдийн засагт хөдөө аж ахуйн салбар нь чухал байр суурь эзэлдэг. Тэр дундаа мал аж ахуй, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн нь амьжиргааны гол эх үүсвэр, анхдагч үйлдвэрлэлийн салбар юм. Манай улсын хувьд дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-д хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг 2021 оны байдлаар 13.0 хувь, үүнээс мал аж ахуйн салбар нь 11.6 хувийг бүрдүүлдэг ба нийт экспортын орлогын 6.0 хувийн хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортоос бүрдүүлж байна. Үйлдвэрлэл талаас нь авч үзвэл, аж үйлдвэрийн салбарын хувьд ДНБ-ий 36.3 хувийг бүрдүүлдэг бол үүний 25.4 хувь (нийт аж үйлдвэрийн нэмэгдэл өртгийн 72.8 хувь) нь уул уурхай, олборлолтын салбар, 8.5 хувь (нийт аж үйлдвэрийн нэмэгдэл өртгийн 21.0 хувь) нь боловсруулах үйлдвэрлэлийн салбараас бүрдүүлдэг.


Ноолууран бараа бүтээгдэхүүн нь аж үйлдвэрийн салбарын боловсруулах үйлдвэрийн нэхмэл болон хувцас үйлдвэрлэлийн салбарын бүтээгдэхүүнд ангилагддаг. Тэгвэл нийт боловсруулах салбарын нийт үйлдвэрлэлийн ойролцоогоор 85 хувийг хөнгөн үйлдвэрийн салбар үйлдвэрлэдэг байсан бол 2021 онд 80 хувь болж буурсан. Дэлгэрүүлж нэхмэл болон хувцас үйлдвэрлэлийн салбарын мэдээллийг авч үзвэл, 2017-2019 онд жилд дунджаар нэхмэл эдлэлийн үйлдвэрлэл 35.4 хувиар, хувцас үйлдвэрлэлийн салбар 10.2 хувийн өсөлттэй байсан. 2020 онд нэхмэл эдлэлийн үйлдвэрлэл 2.3 дахин, хувцас үйлдвэрлэл 1.3 дахин буурчээ. Харин 2021 онд нэхмэл эдлэлийн үйлдвэрлэл сэргэж эргээд 1.9 дахин нэмэгдэж, цар тахлын өмнөх үеийн үйлдвэрлэлийн хэмжээндээ ойртож ирсэн бол хувцас үйлдвэрлэлийн хувьд бууралт нэмэгдэж 2020 оны хэмжээнээсээ 1.6 дахин нэмж буурч 271.7 тэрбум төгрөгт хүрчээ.



Зураг 14. Хөнгөн үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл, тэрбум төгрөгөөр. Эх үүсвэр: YCX, www.1212.mn


Ноолуурын үнэ, ханш

Анхдагч үйлдвэрлэгчийн үнэ буюу малчдын гар дээрээс худалдаж авч буй нэг килограмм ноолуурын жилийн дундаж үнийг Зураг 15-д харуулав. 2021 онд нэг килограмм ноолуурын дундаж үнэ 91.4-92.2 мянган төгрөг байгаа нь 2007 ноос хойших хамгийн их өндөр дүн байна. Сүүлийн жилүүдэд ноолуурын үнэ өсөх хандлагатай байсан ч 2020 онд мэдэгдэхүйц хэмжээгээр буурсан байна. Энэ нь өмнө дурдсанчлан цар тахалтай холбоотойгоор улс орнууд хилээ хаасан, тээвэр ложистикийн асуудлууд тулгарсан зэргээр эрэлт хумигдсан нь түүхий эдийн үнэлгээ дагаад буурсан гэж үзэж болох юм. Хэдийгээр 2021 онд ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тоо хэмжээ буурсан ч түүхий эдийн үнэлгээ нь цар тахлын өмнөх үеэсээ дунджаар 16.6 мянган төгрөгөөр илүү болсон байна. Ноолуурын чанарын хувьд цайвар ноолуурын хувьд илүү чанартай гэж үздэг ба үнэлгээний хувьд бараан ноолуураас бага зэргийн өндөр байдаг байна. Тухайлбал, цагаан нэг килограмм ноолуур 92.2 мянган төгрөг байхад бараан ноолуур 91.4 мянган төгрөг байна.



Зураг 15. Нэг килограмм ноолуурын жилийн дундаж үнэ, мянган төгрөгөөр. Эх үүсвэр: YCX, www.1212.mn

Сайн чанарын ноолуур бэлтгэхийн тулд ямааны ноолуур хөөрөх хугацааг зөв тодорхойлох нь чухал байдаг. Энэ зөв цаг хугацаа нь 3, 4, 5-р сарууд байдаг ба эдгээр саруудад ихэвчлэн малчид ихэнх ноолуур бэлтгэн, борлуулдаг. Ноолуурын дундаж үнэлгээг сараар харвал, шинжилгээнд хамрагдсан жилүүдийн хувьд эдгээр дурьдсан саруудад хамгийн өндөр үнэлгээ тогтдог хандлага ажиглагдаж байна.




Зураг 16. Нэг килограмм ноолуурын дундаж үнэ, мянган төгрөгөөр, сараар. Эх үүсвэр: YCX, www.1212.mn

Ноолуур, ноолууран бүтээгдэхүүний экспорт

Монгол улсын хувьд 2021 оны байдлаар 159 оронтой худалдаа хийж, нийт 16.1 тэрбум америк долларын бараа эргэлтийн хийснээс экспорт 9.2 тэрбум америк доллар байна. Гадаад худалдааны бараа эргэлтийг хөрш 2 оронтой хийдэг худалдаа өндөр жин эзэлдэг. БНХАУ-тай 10.2 тэрбум, ОХУ-тай 2.1 тэрбум америк долларын худалдаа хийсэн ба энэ нь нийт бараа эргэлтийн 76 хувийг эзэлж байна. Экспортын гол нэрийн бараа бүтээгдэхүүнийг авч үзвэл уул уурхайн салбарын бараа бүтээгдэхүүн (зэсийн баяжмал, чулуун нүүрс, алт, төмрийн баяжмал гэх мэт) 80 гаруй хувийг эзэлдэг бол үлдсэн нь уул уурхайн бус салбар (хүнсний бүтээгдэхүүн, ноос, ноолуур, ноолууран бүтээгдэхүүн гэх мэт)-ын бүтээгдэхүүнүүд бүрдүүлдэг. Уул уурхайн бус салбарын экспортын 40 гаруй хувь нь ямааны угаасан болон самнасан ноолуурын экспорт байдаг. Манай улс нь нийт ноолуурын үйлдвэрлэлийн дэлхийн зах зээлийн 40 орчим хувийг дангаараа бүрдүүлдэг. Иймдээ ч Монгол улсын засгийн газраас уул уурхайн бус экспортыг дэмжих салбарын нэгд ноолуурын үйлдвэрлэлийн салбарыг тодорхойлж, эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлэхэд анхаарал хандуулсаар ирсэн.


Нийт гадаад худалдааны экспорт 2001 онтой харьцуулахад 521.5 сая ам.доллараас 9.2 тэрбум ам.доллар болж 17.7 дахин өссөн. Угаасан ноолуурын эргэлт 1238.7 саяас 253.6 сая ам долларт хүрсэн бол самнасан ноолуурын хувьд 55.0 саяас 39.9 сая болж 27 хувиар буурсан. Энэ нь экспортод самнасан ноолуур гаргах нь буурсан, угаасан ноолуур гаргах нь ихэссэн байгааг харуулжээ. Энэ нь засгийн газраас зорьж байгаа нэмүү өртөг шингэдэггүй угаасан ноолуурыг экспортод гаргахыг бууруулах, самнасан ноолуурын экспортыг нэмэгдүүлэх зорилго төдийлөн үр дүнгээ сайн өгөхгүй байгааг эндээс харж болохоор байна.

2001-2021 оны хооронд нийт ноолуурын экспорт 5.2 дахин өссөн ба нийт экспортод ноолуур (угаасан болон самнасан)-ийн эзлэх хувь 11 хувиас 3 хувь болж, 8 пунктээр буурсан.




Зураг 17. Экспортын үнийн дүн, ноолуурын төрлөөр. Эх үүсвэр: YCX, www.1212.mn

Угаасан ноолуурын экспортын хэмжээ хурдацтай нэмэгдсээр 66.3 тонныг экспортод гаргадаг байсан бол 2021 онд 6,026 тонн болтлоо нэмэгджээ. Анх ноолуурыг угаагаагүйгээр шууд экспортод гаргадаг байсан ба 1995-1998 онуудад нийт экспортлосон ноолуурын 44-88 хувийг Их Британи, АНУ болон Итали зэрэг улсуудад экспортолдог байсан, харин 1999 оноос хойш бараг бүх ноолуур БНХАУ-руу худалддаг болсон. 2001 оноос ноолуурыг угааж, гадагш гаргаж эхэлсэн.



Зураг 18. Ноолуурын экспортын хэмжээ, тонноор, ноолуурын үйлдвэрлэлийн үйл явцын төрлөөр. Эх үүсвэр: ГЕГ, www.gaali.mn

Самнасан ноолуурыг авч үзвэл 2006-2010 онуудад харьцангуй их хэмжээгээр экспортод гаргадаг байсан ба тухайн үед нийт гадагш худалдаалагдсан ноолуурын 42-50 хувь нь БНХАУ-руу, 34-43 хувь нь Итали улс руу экспортлогддог байжээ. Харин БНХАУ-аас угаасан болон самнасан ноолуурын худалдан авалтаа бууруулж эхэлсэнтэй холбоотойгоор экспортод гарч буй самнасан ноолуурын хэмжээ 2011 оноос их хэмжээгээр буурсан, харин угаасан ноолуурын хувьд 2013 оноос эргээд нэмэгдүүлсэн. 2013-2021 оны хооронд жилд дунджаар самнасан ноолуурын 77 хувийг Итали, 11 хувийг Их Британи руу худалдаалдаг, харин БНХАУ-руу 5 хувьтай байна.




Зураг 19. Самнасан ноолуурын экспортын хэмжээ, тонноор, улсаар. Эх үүсвэр: ГЕГ, www.gaali.mn

Нийт ноолуур, ноолууран бүтээгдэхүүний экспорт 2012 онд 202.2 сая ам доллар байсан бол 2019 онд хамгийн их буюу 370.4, 2021 онд 334.3 сая ам.доллар байна. Нийт экспортын дунджаар 2-7 хувийг ноолууран пальто, хүрэм, жакет, хослол, өмд, хөнжил зэрэг ноолууран бэлэн бүтээгдэхүүний экспорт бүрдүүлдэг. Нийт ноолууран бүтээгдэхүүний экспорт 2012 онд 6.8 сая ам доллар байсан бол 2019 онд 26.2 сая ам.доллар, 2021 онд 18.8 ам долларт хүрч 2012 оноос 2.7 дахин нэмэгдсэн ч 2019 оноос 28.4 хувиар буурчээ.




Зураг 20. Нийт ноолуур, ноолууран бэлэн бүтээгдэхүүний экспорт, сая ам.доллаар.
Эх үүсвэр: ГЕГ, www.gaali.mn

Ноолууран голлох бүтээгдэхүүнүүдийн экспортыг харвал 2012 оноос хойш хамгийн их хэмжээгээр буюу жилд дунджаар 161,489 ширхэг ноолууран сүлжмэл свитер, джемпер гадагш борлуулагдсан. Үүний дараа ноолууран эмэгтэй өмд дунджаар 16,142 ширхэг, ноолууран даашинз 14,958 ширхэг, ноолууран банзал 3,900 ширхэг, ноолууран хөнжил 3,449 ширхэг, ноолууран пальто, хүрэм, жакет 1,374 ширхгийг экспортолсон байна.




Зураг 21. Голлох ноолууран бүтээгдэхүүний экспорт, тоо ширхэгээр. Эх үүсвэр: ГЕГ, www.gaali.mn


2012-2021 оны хооронд нийт ноолууран бүтээгдэхүүний экспортыг 40 орчим улс орнуудтай хийсэн. Эдгээр улсуудаас 2012, 2019, 2021 онуудын нийт экспортын хэмжээг тооцож харвал, хамгийн их худалдан авалтыг Их Британи (57 мянган ширхэг), ХБНГУ (54 мянган ширхэг), АНУ (51 мянган ширхэг), БНСУ (49 мянган ширхэг), БНХАУ (22 мянган ширхэг), Япон (18 мянган ширхэг), Нидерланд (12 мянган ширхэг), Франц (10 мянган ширхэг) зэрэг улсууд байна.




Зураг 22. Голлох ноолууран бүтээгдэхүүний экспорт, хамгийн их экспорт хийгдсэн улсаар: Ямааны ноолууран пальто, хүрэм, жакет. Эх үүсвэр: ГЕГ, www.gaali.mn




Зураг 23. Голлох ноолууран бүтээгдэхүүний экспорт, хамгийн их экспорт хийгдсэн улсаар: Ямааны ноолууран платье. Эх үүсвэр: ГЕГ, www.gaali.mn




Зураг 24. Голлох ноолууран бүтээгдэхүүний экспорт, хамгийн их экспорт хийгдсэн улсаар: Ямааны ноолууран банзал. Эх үүсвэр: ГЕГ, www.gaali.mn



Зураг 25. Голлох ноолууран бүтээгдэхүүний экспорт, хамгийн их экспорт хийгдсэн улсаар: Ямааны ноолууран эмэгтэй өмд. Эх үүсвэр: ГЕГ, www.gaali.mn



Зураг 26. Голлох ноолууран бүтээгдэхүүний экспорт, хамгийн их экспорт хийгдсэн улсаар: Ямааны ноолууран сүлжмэл свитер, джемпер. Эх үүсвэр: ГЕГ, www.gaali.mn



Зураг 27. Голлох ноолууран бүтээгдэхүүний экспорт, хамгийн их экспорт хийгдсэн улсаар: Ямааны ноолууран хөнжил. Эх үүсвэр: ГЕГ, www.gaali.mn

Голлох бараа бүтээгдэхүүний хувьд худалдан авалтыг дэлгэрүүлж харвал *ноолууран пальто, хүрэм, жакетийг* 2012 онд хамгийн их борлуулалт болох тухайн жилийнхээ нийт экспортын 53 хувь (358 ширхэг)-ийг Япон улстай хийсэн бол 2019 онд 61 хувь (358 ширхэг)-ийг БНСУ-тай, 2021 онд 31 хувь (108 ширхэг)-ийг мөн БНСУ-тай хийсэн. *Ноолууран даашинзны* хувьд 2012 онд 23 хувь (2241 ширхэг)-ийг ОХУ-тай,

2019 онд 57 хувь (13,795 ширхэг)-ийг БНСУ-тай, 2021 онд 31 хувь (4,004 ширхэг)-ийг БНСУ-тай, *ноолууран банзлын* хувьд 2012 онд 72 хувь (665 ширхэг)-ийг ОХУ-тай, 2019 онд 70 хувь (8,759 ширхэг)-ийг БНСУ-тай, 2021 онд 30 хувь (902 ширхэг)-ийг ХБНГУ-тай, *ноолууран эмэгтэй өмдний* хувьд 2012 онд 52 хувь (1,205 ширхэг)-ийг Япон улстай, 2019 онд 57 хувь (22,551 ширхэг)-ийг БНСУ-тай, 2021 онд 38 хувь (11,940 ширхэг)-ийг мөн БНСУ-тай, *ноолууран сүлжмэл свитер, джемперийн* хувьд 2012 онд 36 хувь (44,476 ширхэг)-ийг Их Британитай, 2019 онд 29 хувь (83,002 ширхэг)-ийг БНСУ-тай, 2021 онд 22 хувь (51,107 ширхэг)-ийг Их Британитай, *ноолууран хөнжлийн* 2012 онд 40 хувь (210 ширхэг)-ийг Их Британитай, 65 хувь (4,705 ширхэг)-ийг ХБНГУ-тай, 2021 онд 40 хувь (2,254 ширхэг)-ийг ХБНГУ-тай тус тус хийсэн.

Дэлхийн зах зээлийн ноолуурын ханган нийлүүлэгчид


Нийт дэлхийн зах зээлд жилд дунджаар 24 мянган тонн ноолуурын үйлдвэрлэл явагдаж байгаагаас Хятад ойролцоогоор 50 хувь (12 мянган тонн), Монгол 40 (9.6 мянган тонн) бэлтгэж байна. Харин үлдсэн хэсгийг Иран, Афганистан, ОХУ зэрэг улс орнууд нийлүүлдэг. Тэгвэл Монгол болон Хятадын ноолуурын хувьд цаг уурын нөхцөл байдал, удамшил, ноолуурыг ямаанаас хурааж авах арга барил зэргээс хамааран хоорондоо ялгаатай бүтэцтэй байдаг. Монгол ноолуурын хувьд илүү урт, ширхэгтэй, бохирдол бага, нэг ямаанаас өгөх өгөөж их, мөн байгалиасаа олон өнгөтэй байдаг.

Хүснэгт 5. Монгол, БНХАУ-ын ноолуурын харьцуулалт

	Монгол ноолуур	БНХАУ-ын ноолуур
Гарц	Нэг ямаанаас 350 гр	Нэг ямаанаас 200 гр
Бохирдол	20%-25%	25%-30%
Диаметр	16.5 микрон	15.5 микрон
Урт	42-45 мм	36-38 мм
Өнгө	Байгалийн 4 өнгөтэй	99% нь цагаан өнгөтэй


**-ХХААХҮЯ-ний мэдээлэлд үндэслэсэн МХАҮТ-ын “Ноолуурын зах зээлийн мэдээлэл” танилцуулга, 2021*

Ноолууран бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлээрээ Итали болон Их Британи улсууд тэргүүлдэг. Дэлхийн угаасан ноолуурын хамгийн том импортлогч улсууд 2020 оны мэдээллээр Итали (82%), Их Британи (82%), Өмнөд Солонгос (82%), Герман (82%), Япон (82%) улсууд байсан бол самнасан ноолуурын импортлогч улсууд Мадагаскар (82%), Итали (82%), Өмнөд Солонгос (82%), Босни ба Герцеговин (82%) болон Норвеги (82%) улсууд багтжээ.




Зураг 28. Угаасан болон Самнасан ноолуур хамгийн их импортолсон улсууд*, 2020. Эх үүсвэр: www.trademap.org. *- www.trademap.org -ний мэдээлэлд үндэслэсэн МХАҮТ-ын “Ноолуурын зах зээлийн мэдээлэл” танилцуулга, 2021

Италийн Шнейдер группийн гаргадаг ноолуурын зах зээлийн индикаторыг харвал ноолуурын үнэлгээ ерөнхийдөө өсөх хандлагатай байна. 2020 онд түүхий эдийн үнэлгээ мэдэгдэхүйц хэмжээгээр буурсан нь Ковид-19 цар тахлын нөлөөгөөр дэлхийн хэмжээнд ноолууран бараа бүтээгдэхүүний эрэлт буурсан нь нөлөөлсөн байж болох юм. Тэгвэл 2021 онд түүхий эдийн үнэ эргэж сэргэсэн нь мөн цар тахлын нөлөө суларсантай холбоотойгоор байж болно. Уг индикатороос харахад Хятадын ноолуурын үнэлгээ хамгийн өндөр, үүний дараа Монгол, Ираны ноолуурууд ордог. Хятадын ноолуурын хувьд 2013 онд хамгийн өндөр үнэлгээнд хүрч байсан бол Монгол, Иран ноолуурын хувьд 2011 онд хамгийн өндөр үнэлгээнд хүрч байжээ.



Зураг 29. Ноолуурын зах зээлийн индикатор. Эх үүсвэр: www.gschneider.com

Дэлхийн малын тоог авч үзвэл НҮБ-ын Хүнс Хөдөө аж ахуйн байгууллагын мэдээллийн санд 2020 оны байдлаар дэлхийн хэмжээнд 4,000.1 сая толгой мал байгаагаас 1,128.1 сая (28.2%) нь ямаа байна.



Зураг 30. Дэлхий нийт малын тоо, сая толгойгоор. Эх үүсвэр: НҮБ-ын ХХААБ

Нийт малын 40.5 хувь нь Ази, 33 хувь нь Африк, 17.2 хувь нь Америк, 6.2 хувь нь Европ, 3.2 хувь нь Австрали тив болон далайн орнуудад байна. Ямааны тоогоор 1-д Энэтхэг улс (150.2 сая), 2-д БНХАУ (133.5 сая), 3-д Нигери (83.7 сая), 4-д Пакистан (78.2 сая), 5-д Бангладеш (60.0 сая), 6-д Чад (52.4 сая), 7-д Кени (41.1 сая), 8-д Судан

(32.2 сая), 9-д Мали (27.8 сая), 10-д Монгол нэрлэгддэг бол ноолуурын зах зээлийн томоохон нийлүүлэгч Иран улсын хувьд 13-д 16.6 сая толгойгоор эрэмлэгддэг байна.

Хүснэгт 6. Дэлхийн малын тоо, бүс нутгаар, сая толгойгоор

	2015	2016	2017	2018	2019	2020
Дэлхий	3716.4	3774.9	3796.6	3838.4	3940.4	4000.1
Африк	1134.8	1168	1188.6	1215	1267.8	1319.2
Америк	663.7	670.9	672.4	675.6	682.3	686.3
Ази	1500.1	1525.7	1519.3	1537	1591.5	1619.4
Европ	275.3	275.1	275.4	272	266	247.8
Австрали	142.4	135.3	140.9	138.8	131.7	127.4

Эх үүсвэр: НҮБ-ын ХХААБ

Дүгнэлт

Ноолуурын зах зээл нь Монгол улсын эдийн засагт чухал байр суурь эзэлдэг. Малчдын хувьд ноолуур нь амьжиргааны гол эх үүсвэр болж байдаг бол уул уурхайн бус салбарын тэргүүлэгч экспортын бүтээгдэхүүн гэдэг утгаараа эдийн засагт үзүүлэх ач холбогдол нь мөн их байдаг. Монгол улсын засгийн газраас ноолуур үйлдвэрлэлийн салбарыг тусгайлан авч үзсэн бодлогын хөтөлбөр бол “Ноолуур” хөтөлбөр юм. Ноолуурын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн техник, технологийг хөгжүүлэх, эцсийн бүтээгдэхүүний нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, экспортыг дэмжих зорилгоор “Ноолуур” хөтөлбөрийг анх 2000-2006 онуудад хэрэгжүүлсэн.

Энэхүү судалгаанд гарсан гол үр дүнг томъёолбол:

- 2018-2021 онуудад дахин баталж, хэрэгжүүлсэн. Мөн ноолуурын салбарыг дэмжих зорилгоор 2011-2020 оны хооронд 183 аж ахуйн нэгж байгууллагад 726.8 тэрбум төгрөгийн хөнгөлттэй зээлийг олгосон байна. Монгол улсын нийт малын тоо 1970 онтой харьцуулахад 3 дахин өсөж 67.3 сая толгойд хүрсэн бол ямааны тоо 6.3 дахин өсөж 26.5 саяад хүрсэн байна. 2021 оны байдлаар 920.2 мянган өрх байгаагийн 188.6 мянган нь жилийн дөрвөн улиралд малаа малладаг, малын ашиг шим нь амьжиргааны эх үүсвэр нь болдог өрхүүд байна. Нэг малчин өрхөд ногдох ямааны тоо дунджаар 67-оос 146 толгой болж 2.2 дахин нэмэгдсэн байна.
- 2021 оны дүнгээр нийт 10.1 мянган тонн ноолуур бэлтгэсэн ба энэ нь өмнөх оноосоо 6 хувиар буурсан хэдий ч 2001 оноос 3.3 дахин нэмэгдсэн дүн юм. Ноолуурын үйлдвэрлэлийг харвал ямааны тооны өсөлтэй ижил хандлагатай өөрчлөгдсөн ба сүүлийн жилүүдэд малчид малын чанарт бус тоонд анхаарч малаа өсгөснөөс, түүхий эдийн чанар болон нэг малаас авах ашиг шимийн хэмжээ буурсан гэж дүгнэгдэх болсон байна. Нийт ноолуурын ойролцоогоор 50-аас дээш хувийг Өмнөговь, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Дундговь, Ховд, Хөвсгөл аймгууд бүрдүүлдэг байна.

- 2011 оны байдлаар нийт бэлтгэсэн 6.5 мянган тонн ноолуурын 3.0 хувийг дотоодын үйлдвэрт угааж байсан бол цар тахлын өмнөх үе болох 2019 онд 12.9 хувийг, 2021 онд 22.1 хувийг угаасан. Самнасан ноолуурын хувьд нийт бэлтгэсэн ноолуурын 2011 онд 16.0 хувь, 2019 онд 7.8 хувь, 2021 онд 5.1 хувь, ноолууран ээрмэлийн хувьд 2011 онд 3.9 хувь, 2019 онд 3.4 хувь, 2021 онд 0.5 хувиар ноолууран ээрмэл бэлтгэсэн байна.
- 2021 онд угаасан ноолуур мэдэгдэхүйц хэмжээгээр нэмэгдсэн. Энэ нь Хятад улс Ковид-19-ийн тархалттай нөлөөгөөр хилээ хаасантай холбоотойгоор дотоодын үйлдвэрт угааж, бэлтгэх нь ихэссэн байж болно. Гэхдээ, үүнийгээ дагаад самнасан болон ноолууран ээрмэл бэлтгэх үйл явц тэр хэмжээгээр нэмэгдээгүй. Эсрэгээрээ 2021 онд ноолууран ээрмэлийн үйлдвэрлэл 245.5 тонноос 47.4 тонн болж, 80 гаруй хувиар буурчээ. Үүнийг мөн цар тахлын нөлөөгөөр экспортын үйл ажиллагаа саарсан, өрхийн орлого буурч, хэрэглэгчийн зан төлөв өөрчлөгдсөн, жуулчдын тоо багассан зэргээс шалтгаалан эрэлт багассантай холбон тайлбарлагдах боломжтой юм.
- 2012 оныг хүртэл жилд дунджаар нийт ноолуурын үйлдвэрлэлийн 21 орчим хувийг дотоодын үйлдвэрт самнадаг байсан бол 2021 оны дүнгээр 5 хувь болж буурсан. 2012 оноос хойш 2017-2018 онуудад хамгийн их боловсруулалт хийгдэж байсан бол 2020 оноос 512 тонн болж, 2018 оноос 55.5 хувиар, 2019 оноос 33.2 хувиар буурсан.
- Сүүлийн 20 жилийн хугацаанд 2002-2006 онуудад хамгийн их буюу жилд 3.4-5.6 сая ширхэг сүлжмэл, нэхмэл, эдлэлийг үйлдвэрлэсэн. Үйлдвэрлэлийн хэмжээ 2007 оноос эрс буурч, жилд дунджаар ойролцоогоор 760 мянган ширхэг бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн бол 2017 оноос сэргэж 2019 онд 1,730 мянгад хүрсэн ч 2020 оноос буурч, 2021 онд 2019 оноос 3.3 дахин буурч 524 мянгад хүрчээ.
- 2019 оны байдлаар сүлжих үйлдвэрлэл хувьд хүчин чадлын ашиглалтаараа хамгийн их буюу нийт суурилагдсан хүчин чадлын 66.1 хувийг үйлдвэрлэлд ашигладаг бол угаах, хялгас ялгах, ээрэх, нэхэх үйлдвэрлэлийн хувьд суурилагдсан хүчин чадлынхаа 24.9-31.5 хувийг л ашиглаж байдаг байна.

- Нэг килограмм ноолуурын үнэ сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байсан ч 2020 онд мэдэгдэхүйц хэмжээгээр буурсан. Энэ нь мөн цар тахалтай холбоотойгоор улс орнууд хилээ хаасан, тээвэр ложистикийн асуудлууд тулгарсан зэргээр эрэлт хумигдсанаар түүхий эдийн үнэлгээг буурахад нөлөөлсөн. 2021 онд эргээд өссөн ба нэг килограмм ноолуурын дундаж үнэ 91.4-92.2 мянган төгрөг байгаа нь 2007 ноос хойших хамгийн их өндөр дүн байна.
- 2021 онд угаасан ноолуурын экспорт 2001 онтой харьцуулахад 1,238.7 мянга ам доллароос 253.6 сая ам долларт хүрсэн бол самнасан ноолуурын хувьд 55.0 саяас 39.9 сая болж 27 хувиар буурсан. Нийт ноолуурын экспорт 5.2 дахин өссөн, харин нийт экспортод ноолуур (угаасан болон самнасан)-ын эзлэх хувь 11 хувиас 3 хувь болж, 8 пунктээр буурсан. Бараг бүх угаасан ноолуур БНХАУ-руу экспортлогддог бол самнасан ноолуурын хувьд Итали, Их Британи, БНХАУ гол импортлогч орнууд байна.
- Нийт ноолуурын экспортын 2-7 хувийг ноолууран бэлэн бүтээгдэхүүний экспорт бүрдүүлж байна. Ноолууран бэлэн бүтээгдэхүүнээс хамгийн их хэмжээгээр ноолууран сүлжмэл свитер, джемперийг экспортод гаргадаг ба 2012-2021 оны хооронд жилд дунджаар 161,489 ширхгийг экспортолжээ.
- Ноолууран бүтээгдэхүүний экспортыг 2012-2021 оны хооронд 40 орчим улс орнуудтай хийсэн. Эдгээр улсуудаас хамгийн их худалдан авалтыг Их Британи, ХБНГУ, АНУ, БНСУ, БНХАУ, Япон, Нидерланд, Франц зэрэг улсууд байна. *Ноолууран пальто, хүрэм, жакетийг* 2012 онд хамгийн их борлуулалт болох тухайн жилийнхээ нийт экспортын 53 хувийг Япон улстай хийсэн бол 2019 онд 61 хувийг БНСУ-тай, 2021 онд 31 хувийг мөн БНСУ-тай хийсэн. *Ноолууран даашинзны хувьд* 2012 онд 23 хувийг ОХУ-тай, 2019 онд 57 хувийг БНСУ-тай, 2021 онд 31 хувийг БНСУ-тай, *ноолууран банзлын хувьд* 2012 онд 72 хувийг ОХУ-тай, 2019 онд 70 хувийг БНСУ-тай, 2021 онд 30 хувийг ХБНГУ-тай, *ноолууран эмэгтэй өмдний хувьд* 2012 онд 52 хувийг Япон улстай, 2019 онд 57 хувийг БНСУ-тай, 2021 онд 38 хувийг БНСУ-тай, *ноолууран сүлжмэл свитер, джемперийн хувьд* 2012 онд 36 хувийг Их Британитай, 2019 онд 29 хувийг БНСУ-тай, 2021 онд 22 хувийг Их

Британитай, *ноолууран хөнжлийн* 2012 онд 40 хувийг Их Британитай, 65 хувийг ХБНГУ-тай, 2021 онд 40 хувийг ХБНГУ-тай тус тус хийсэн байна.

- Дэлхийн зах зээлд жилд дунджаар 24 мянган тонн ноолуурын үйлдвэрлэл явагдаж байгаагаас Хятад ойролцоогоор түүхий эдийн 50 хувь, Монгол 40 орчим хувийг бэлтгэж, үлдсэн хэсгийг Иран, Афганистан, ОХУ зэрэг улс орнууд бэлтгэж байна. Дэлхийн угаасан ноолуурын хамгийн том импортлогч улсаар Итали, Их Британи, Өмнөд Солонгос, Герман, Япон улсууд байдаг. Харин самнасан ноолуурын хувьд Мадагаскар, Итали, Өмнөд Солонгос, Босни ба Герцеговин болон Норвеги улсууд тооцогддог.
- Дэлхийн зах зээлд ноолуурын үнэлгээ ерөнхийдөө өсөх хандлагатай байна. Ноолуурын түүхий эдийн үнэлгээ 2020 онд мэдэгдэхүйц хэмжээгээр буурсан ба 2021 онд үнэ эргэж өссөн. Энэ нь Ковид-19 цар тахлын нөлөөгөөр дэлхийн хэмжээнд ноолууран бүтээгдэхүүний эрэлт буурсан, харин 2021 онд цар тахлын нөлөө суларсантай зэрэгцээд үнэ эргэж өссөн байж болох юм.

Ашигласан материал

- Говь ХК. (2021). Жилийн тайлан-2020, Улаанбаатар, Говь Хувьцаат Компани
- МХАҮТ. (2021). Ноолуурын зах зээлийн мэдээлэл, Улаанбаатар. Монголын
Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын Судалгааны Институт
- С.Сайнбаяр ба бус. (2021). Монгол орны мал аж ахуйн салбарт зудын давтамжийн
үзүүлж буй хохирлын үнэлгээ, Mongolian Journal of Agricultural Sciences, Vol
32, No 1
- Тогтвортой ноос ноолуурын эвсэл, Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ
мэдээлэл, арга зүйн төв. (2021). Ямааны ноолуур ангилан бэлтгэх гарын авлага,
Улаанбаатар
- ҮСХ. (2021). Аж Үйлдвэрийн салбарын танилцуулга-2021, Улаанбаатар. Үндэсний
Статистикийн Хороо
- ҮСХ. (2001-2022). “Хөдөө Аж Ахуйн салбарын танилцуулга-2000-2021”,
Улаанбаатар, Үндэсний Статистикийн Хороо,
- ҮСХ. (2022). Гадаад худалдааны салбарын танилцуулга-2021, Улаанбаатар, Үндэсний
Статистикийн Хороо
- ХХААХҮЯ. (2021). Монгол ноолуур боловсруулах үйлдвэрлэлийн салбарын
танилцуулга-2020, Улаанбаатар, Хүнс, Хөдөө, Аж Ахуй, Хөнгөн
Үйлдвэрлэлийн Яам

Цахим мэдээллүүд

- Гаалийн Ерөнхий газар. «ГААЛИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СИСТЕМ». Gaali.mn, 2022. <https://gaali.mn>.
- Монгол Улсын Засгийн газар. «НООЛУУР» ХӨТӨЛБӨР, 114 Тогтоол (2000). <https://legalinfo.mn/mn/detail?lawId=201406&showType=1>.
- . “НООЛУУР” ХӨТӨЛБӨР (2018-2021), 47 Тогтоол (2018). <https://legalinfo.mn/mn/detail?lawId=13204>.

- . “ҮЙЛДВЭРЖИЛТ 21:100” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР (2018-2021), 36
Тогтоол (2018). <https://legalinfo.mn/>.
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам. «MOFA - Нүүр», 2022.
<https://www.mofa.gov.mn/home>.
- International Trade Centre. «Trade Map - Trade statistics for international business
development», 2022. <https://www.trademap.org/Index.aspx>.
- The Schneider Group. «The Schneider Group - Wool Top - Dehaired Cashmere - Silk»,
2022. <https://www.gschneider.com/home/>.
- UNDP. «CASHMERE INITIATIVES WORKING TOGETHER TO IMPROVE
THE VALUE CHAIN», 2022. [https://www.undp.org/mongolia/blog/cashmere-
initiatives-working-together-improve-value-chain](https://www.undp.org/mongolia/blog/cashmere-initiatives-working-together-improve-value-chain).